Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн
02/160 дугаар албан бичгийн
хавсралт

9024010070 СТС4589 9077448

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН
СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
(2024 оны эхний хагас жил)

2024 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаа | № | | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин 2024 оны эхний хагас жил | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 7 |
| ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХИЖҮҮЛЭХ | | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | | Нийт сургалт, семинар. зөвлөгөөний тоо | 38 | 26 | Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн Архивын газар зэрэг 10 гаруй байгууллагаас зохион байгуулсан 26 (17 танхим, 12 цахим) удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 гаруй албан хаагчдын сахилга бат, ажлын хариуцлагыг сайжруулах, ажын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр суралцуулсан. ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хороо БНХАУ-ын Бээжин хотын спортын их сургуульд Монгол Улсын биеийн тамир, спортын төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 18-24-ний өдрүүдэд зохион байгуулсан тус сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн |
| | | Үүнээс | | Ажлын байран дахь сургалт | 1 | - | |
| | | | | Мэргэшүүлэх сургалт | 2 | 3 | |
| | | | | Туршлага солилцох арга хэмжээ | 1 | 1 | |
| | | | | Бусад | 25 | 25 | |
| | | 1.2. | | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо | 100 | 100 | |
| | | Үүнээс | | Эмэгтэй албан хаагч | 60 | 50 | |
| | | | | Эрэгтэй албан хаагч | 40 | 20 | |
| | | | | Удирдах албан тушаалтан | 3 | 3 | |
| | | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 100 | 100 | |

<table>
<tr><td></td><td></td><td>1.3.</td><td>Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь</td><td>100</td><td>100</td><td>хэлтсийн Ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан хамрагдаж туршлага судлан сертификат эзэмшсэн бөгөөд байгууллагын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар 890,000 төгрөгийн онгоцны зардлыг байгууллагаас шийдвэрлүүлсэн.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Удирдлагын академитай хамтран төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 40 цагийн чиглүүлэх багц сургалтад 3 албан хаагч улсын төсвийн зардлаар суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлж, үнэмлэх гардан авсан.<br>Хэрэгжилт-100</td></tr>
<tr><td rowspan="7">2.</td><td rowspan="7">Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт</td><td>2.1.</td><td>Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо</td><td>2</td><td>2</td><td rowspan="7">ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хороо БНХАУ-ын Бээжин хотын спортын их сургуульд Монгол Улсын биеийн тамир, спортын төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 18-24-ний өдрүүдэд зохион байгуулсан тус сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан хамрагдаж туршлага судлан сертификат эзэмшсэн бөгөөд байгууллагын даргын 2024 оны А/12 дугаар тушаалаар 890,000 төгрөгийн онгоцны зардлыг байгууллагаас шийдвэрлэж өгсөн.<br>Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад арга хэмжээг өргөжүүлэх ажлын хүрээнд Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотод Дэлхийн жүдо бөхийн холбооны хурал, Сөүл хотын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээний арга хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын 04-09-ний өдрүүдэд байгууллагын дарга оролцож, Монгол Улсын хэмжээнд Жүдо бөхийн хөгжил, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж, илтгэл тавьсан.<br>Хэрэгжилт-100</td></tr>
<tr><td>2.2.</td><td>Хамрагдсан нийт албан хаагчдын тоо</td><td>2</td><td>2</td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс</td><td>Эмэгтэй албан хаагч</td><td>4</td><td>2</td></tr>
<tr><td>Эрэгтэй албан хаагч</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>Удирдах албан тушаалтан</td><td>2</td><td>-</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх, туслах албан тушаалтан</td><td>-</td><td>1</td></tr>
<tr><td>2.3.</td><td>Гадаад сургалтад хамруулсан байдал нийт албан хаагчдад эзлэх хувь</td><td>20 - оос дээш</td><td>20%</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 1,870,0 | - | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Удирдлагын академитай хамтран Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 40 цагийн чиглүүлэх багц сургалтад 2024 оны 03 дугаар сарын 12-28-ны өдрүүдэд 3 албан хаагч улсын төсвөөс зардлаар суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлж, үнэмлэх гардан авсан. |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бөгөөд тухайн байгууллагадаа 4-өөс дээш жил ажилласан албан хаагчид ажиллаж байна. Хэрэгжилт-100 |
| АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ | | | | | | |
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | 80% | 80% | Байгууллагын жилийн төсвийн 90 хувийг албан хаагчдын цалин, шагнал, урамшууллын зардал эзэлж байна. 2024 онд цалинд нийтдээ 134,763,479 төгрөг зарцуулсан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр үнэлж, дүгнэн А, В үнэлэгдсэн албан хаагчдад урамшуулал 34,935,500 төгрөгийг зарцуулсан байна. |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 8000 | 8000 | 2024 оны 01 дүгээр сарын 02-ны байгууллагын даргын А/01 тушаалаар албан хаагчийн нэг өдрийн хоолны зардал 7000, унааны зардалд 1000 төгрөгөөр тогтоож сар бүр олгож байгаа бөгөөд нийт 10 албан хаагчдад эхний хагас жилийн байдлаар 10,080,0 сая төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт-100 |
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80 - аас дээш | 90 хувь | Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 10 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд 9 албан хаагч буюу дарга-1, хэлтсийн дарга-1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-5 хамрагдсанаас 72 асуулгаар авсан бөгөөд үр дүн нь Нийслэлийн биеийн тамир, спортын газрын албан хаагчид байгууллагын удирдлага, хэлтсийн дарга нарын удирдахуйн ухаанд сэтгэл ханамжтай, ажилдаа дуртай ч ажиллах нөхцөл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломж, дутмаг, ажлын ачаалал ихтэй болох нь судалгаагаар гарсан.<br>Хэрэгжилт-100 |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) | 1 - ээс дээш | - | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгийг байгууллагын хэмжээнд зохион байгуулахад улс болон нийслэлийн төсөвт төсөв тусгагдаагүйн улмаас 2 албан хаагч хувиараа эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна. |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 90 - ээс дээш | 20% | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт 2 албан хаагч хувиараа хамрагдсанаар байгууллагын албан хаагчдын 20%-нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.<br>Хэрэгжилт-50 |
| 7. | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 25,055,460 | 2,500,000 | Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хууль, Нийслэлийн Засаг даргын А/1430 дугаар захирамжаар албан хаагчдын цалин хөлсийг бууруулахгүйгээр долоо хоногийн 1 өдөр зайнаас болон цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, байгууллагын даргын 2024 оны А/08 дугаар тушаалаар албан хаагчдын зайнаас цахимаар ажиллах хуваарийг баталж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Нийтийн тээврийн зардалд нэг албан хаагчдад 1 өдрийн 1000 төгрөг бөгөөд 1,260,000 төгрөг зарцуулсан.<br>Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ахмадуудыг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 280.000 төгрөгийг байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар шийдвэрлүүлсэн.<br>Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн А.Намуун |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нь 2024 оны 03 дугаар сарын сүүлээр “Солонго Хараа”-д нүдний хиймэл нүдний болор шилжүүлэн суулгах мэс ажилбарт ороход 660,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны Б/03 тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламжыг олгуулсан.<br>Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргалын хадам ээж нь 2023 оны 12 дугаар сарын сарын 27-ны өдөр нас барсанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 300,000 төгрөгийг 2024 оны 02 дугаар сарын 20-ны Б/02 дугаар тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламж олгуулсан.<br>Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад арга хэмжээг өргөжүүлэх ажлын хүрээнд Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотод Дэлхийн жүдо бөхийн холбооны хурал, Сөүл хотын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээний арга хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын 04-09-ний хооронд байгууллагын дарга оролцож Монгол Улсын хэмжээнд Жүдо бөхийн хөгжил, тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж, илтгэл тавьсан.<br>Хэрэгжилт-100 |
| 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилт 92.8 хувь | | | | | | |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА